



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/464

Улаанбаатар хот

Зааварчилгаа батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг” байгуулах зааварчилгааг хавсралтаар баталсугай.

2. Томуу, томуу төст өвчний тархалтын “Алаг цоог дэгдэлт”-ийн түвшингээс эхлэн аймаг, дүүргийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсгийг гаргаж, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хуваарилалтыг гарган ажиллахыг аймаг, нийслэлийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга захирал нарт үүрэг болгосугай.

3. Томуугийн үзлэгийн хэсэг байгуулахад зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д тус тус үүрэг болгосугай.

4. Томуугийн үзлэгийн хэсэг байгуулахад мэргэжил арга зүйгээр хангах, хүний нөөцийг чадавхжуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шаардлагатай сургалтыг зохион байгуулж ажиллахыг Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Ш.Энхтөр), Эмнэлгийн чанар, аюулгүй байдлын мэргэжлийн салбар зөвлөл (Б.Баясгалантай), Халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Д.Наранзул)-д тус тус үүрэг болгосугай.

5. “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг”-т үзүүлж буй тусламж, үйлчилгээний санхүүжилтийг амбулаторийн тусламж, үйлчилгээний багцын дагуу олгож, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141252319

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 12
дугаар сарын 08-ны өдрийн дугаар
тушаалын хавсралт 1/464



**“ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ТОМУУГИЙН ҮЗЛЭГИЙН ХЭСЭГ” БАЙГУУЛАХ ЗААВАРЧИЛГАА**

Нэг. Зорилго

Эмнэлгийн нэгжийг аймаг, дүүргийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед эмнэлгийн ачааллыг бууруулах, үйлчлүүлэгчийн эрсдэл, хүндрэлийг эрт илрүүлж, эмчилгээний хожимдол үүсгэхгүйн тулд үзлэг, оношилгоонд түргэн шуурхай хамруулан эрэмбэлж, тусламж, үйлчилгээг чиглүүлэх үүрэгтэй, халдвараас сэргийлэх дэглэмийг баримталсан “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг” байгуулж ажиллах.

Хоёр. Зохион байгуулалт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг” эмнэлгийн үндсэн урсгалаас тусдаа байна.

2.2. Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтан орох урсгал, хүлээн авах хэсэг, үзлэгийн өрөө, эмчилгээний өрөө, сорьц авах хэсэг, гарах урсгалыг тусгаарласан зохион байгуулалттай байна.

2.3. “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг”-т оношлох, зөвлөгөө өгөх их эмч, эрэмбэлэн ангилах сувилагч, тархвар судлагч эмч/хяналтын ажилтан, бүртгэл мэдээллийн ажилтан, туслах ажилтан, үйлчилгээний албан хаагч зэрэг эрүүл мэндийн ажилтан ажиллана.

2.4. “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг” нь дараах үйл ажиллагааг хийнэ. Үүнд:

- 2.4.1. томуу, томуу төст өвчний шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийг үзэж, эрэмбэлэн ангилах, оношлох;
- 2.4.2. томуу, томуу төст өвчний сэжигтэй хүнийг түргэвчилсэн тестээр оношлох
- 2.4.3. Эрэмбэлэн ангиллын дагуу шаардлагатай өвчтөнийг яаралтай тусламжийн тасагт шилжүүлэх;
- 2.4.4. Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй эм бичих;
- 2.4.5. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх заалтыг гаргах;
- 2.4.6. Эмчилгээг гэрээр хийж буй өвчтөний давтан үзлэг, эмчилгээний хяналтыг хийх, зөвлөгөө өгөх;
- 2.4.7. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх.

Гурав. Халдварын сэргийлэлт хяналт:

3.1. Томуугийн үзлэгийн хэсэг агааржуулалтын системтэй, цонхоор агаар сэлгэлт хийх боломжтой, агааржуулалтыг тогтмол хийнэ.

3.2. Эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгч гарын эрүүл ахуй сахих нөхцөл бүрдүүлсэн, үзлэг, эмчилгээний өрөөнүүд гарын угаалтууртай, тусламж үйлчилгээний болон үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэгт гэсэн бүх байршилд гар халдваргүйжүүлэх бодис байрлуулсан байна.

3.3. Эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгч амны хаалт зүүнэ.

3.4. Хүн хооронд 1-1.5 м зай барина.

3.5. Эмнэлгийн орчинд чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа хийнэ.

3.6. Олон хүний гар хүрч амархан бохирддог гадаргууг арчиж халдваргүйжүүлнэ.

3.7. Эмнэлгийн ажилтныг томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан байна.

3.8. Ажиглан тусгаарлах өрөө нь ариун цэврийн өрөө, гар угаах боломжтой, бэлэн байдлыг хангасан байна.

3.9. Үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ стандарт болон нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг мөрдөнө.

3.10. Халдварын сэргийлэлт хяналтын тушаал, журам, зааврын хэрэгжилтийг хангаж ажиллана.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын үүрэг

1.1. Томуу, томуу төст өвчний эмнэлзүйн зааврын хэрэгжилтийг хангахад чиглэсэн сургалт, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

1.2. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэгт ажиллах эмнэлгийн ажилтны хуваарь, үүрэг чиглэлийг тодорхой тусгасан заавар, журмыг байгууллагын түвшинд гарган хэрэгжилтийг хангана.

1.3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсгийн байршил, ажиллах цагийн хуваарь, үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

1.4. Томуугийн шинж тэмдэг, гэрийн дэглэм, бага насны хүүхдийн асаргаа, хоололт зэрэг томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдвараас сэргийлэх дэглэм, зөвлөгөө түгээх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

Тав. Мэдээ, мэдээллийн урсгал

5.1. “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх томуугийн үзлэгийн хэсэг”-ийн үзлэг, тохиолдлын тоог шинж тэмдэг, ангиллаар холбогдох маягтын дагуу өдөр бүр эмнэлгийн цахим мэдээллийн системд тайлагнана.